



Үнэт цаасны зах зээл дэх боломж, хамтын ажиллагаа



Хэсэг 1 **Үнэт цаасны зах зээлийн зайлшгүй шаардлага**

Хэсэг 2 **Одоогийн нөхцөл байдал**

2.1 Үнэт цаасны зах зээлийн үе шат

2.2 Хүрсэн үр дүн

2.3 Тулгамдаж байгаа асуудлууд

2.4 Дэмжлэг, хөшүүрэг

Хэсэг 3 **Зах зээлийн зохицуулалтын механизм**

Хэсэг 4 **Шийдэл, гарц, хамтын ажиллагаа**

Хэсэг 5 **Хавсралт**


5.1 Стратегийн ордууд

5.2 Мэргэжлийн оролцогчид




Үнэт цаасны зах зээлийн зайлшгүй шаардлага

Монгол Улс зээлд суурилсан эдийн засагтай байна.



Өрийн хүүний төлбөр: 270.5 тэрбум төг /2013/

Зээлийн хүүний төлбөр: 1433.9 тэрбум төг /2013/





Одоогийн нөхцөл байдал

Үнэт цаасны зах зээлийн түүхэн үе шатууд


- **Хувьчлалын үе. /1991-1995/** 470 үйлдвэрийн газрыг хувьцаат компани болгож зохион байгуулж Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлсэн. ХОЭБ-ээр 96.4 сая хувьцааг 1.2 сая хүн хувьцаа эзэмшигч болсон.
- **Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн. /1995-2005/** Хувьчилсан компаниудын анхдагч зах зээлийн арилжаа дуусч, хувьцаа эзэмшигчид өөр хоорондоо хувьцаа арилжаалж эхэлсэн.
- **Шинэ компаниуд хувьцаа болон бонд гаргаж эхлэв. /2005-2011/** Нийт 14 Компани хувьцаа шинээр болон нэмж хувьцаа гаргаж, 16 компани компанийн бонд арилжаалж, зах зээлээс 101.86 тэрбум төгрөг босгов.
- **Шинэчлэлүүд хийгдэж эхлэв. /2012-одоог хүртэл/**

Хийгдсэн ажлууд		Үр дүн
Хууль эрх, зүйн шинэчлэл	Компанийн тухай хууль (2011-10-6) Үнэт цаасны тухай хууль (2013-5-31) Сангийн тухай хууль (2013-10-3)	•Шинэ бүтээгдэхүүн, оролцогчид бий болох оролцох боломжууд •Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг •Компанийн засаглал
Дэд бүтэц	MIT	•Олон улсын жишигт хүрсэн.
Төлбөр тооцоо	T+3	•Эрсдэлийг бууруулсан. •Дэд бүтцийг боловсронгуй болгосон.

Одоогийн нөхцөл байдал




Хувьцаат компаниудын тоо




Хөрвөх чадвар



Хувьцааны арилжааны үнийн дүн



Топ 20 индекс





Тулгамдаж байгаа асуудлууд

	Хөрөнгө оруулагч	Компаниуд	Мэргэжлийн хөрөнгө оруулагч	Шинэ бүтээгдэхүүн
Юу хүсч байна	<ul style="list-style-type: none"> •Оруулсан хөрөнгө оруулалтын хяналт •Тогтвортой байдал •Мэдлэг мэдээлэл •Чанартай бүтээгдэхүүн 	<ul style="list-style-type: none"> •Хөрөнгө оруулалт, санхүүжилт •Компанийн нөхцөл боломжид тохирсон шалгуур, шаардлага •Тогтвортой байдал 	<ul style="list-style-type: none"> •Хууль эрх зүйн орчны уялдаа •Мэдээлэл, мэдлэг 	<ul style="list-style-type: none"> •Эрх зүйн орчин •Дэд бүтэц •Мэргэшсэн боловсон хүчин •Мэдээлэл
Нөхцөл байдал	Итгэлгүй	Хөрөнгө оруулалт, санхүүжилт босохгүй	Зах зээлд орж ирэхгүй	Байхгүй
Үр дүн	<ul style="list-style-type: none"> •Шинээр хөрөнгө, санхүүжилт босгох компани байхгүй. •Арилжаа буурсан. •Хөрвөх чадваргүй. •Зах зээлийн үнэлгээ буурсан. 		Үнэт цаасны зах зээл хямралд ороод байна.	
Шалтгаан	<ul style="list-style-type: none"> •Зах зээлийг хөгжүүлэх нэгдсэн бодлогын баримт бичиг байхгүй •Зах зээлийг судалж, шинжилдэггүй, эрсдэл гарах үр дүнг тооцдоггүй •Бусад салбартай уялдаа холбоо байдаггүй •Хууль эрх, зүйн орчны шинэчлэлт хурдан хийгдээгүй. 			

Дэмжлэг, хөшүүрэг



Зах зээлийг хэвийн ажиллуулахад тодорхой хугацаанд дэмжлэг, хөшүүрэг шаардлагатай байна:

Татварын хөнгөлөлт
чөлөөлөлт

- ХК-ийн бүртгэлийг харгалзаж ААНОАТ-ыг хөнгөлөх
- Хөрөнгө оруулагчдын ногдол ашиг болон ханшийн зөрүүний ашгийг татвараас чөлөөлөх

Төсөл хөтөлбөр

- Улсаас Сангуудад мөнгөн хөрөнгө байршуулж, удирдуулж, хөрөнгө оруулалт хийлгэх
- Нийгмийн даатгал болон бусад үнэт цаасны мэргэжлийн компаниудыг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх боломжийг нээж өгөх
- Үнэт цаасны оролцогчдын боловсон хүчинг чадавхижуулах
- Дэд бүтцийн бүрэн шийдвэрлүүлэх

Хувьчлалыг
үргэлжлүүлэх

- 2008 оноос хойш одоог хүртэл МХБ-д төрийн компаниудад бодит утгаараа хувьчлал хийсэн компани байхгүй байна.

Стратегийн ордуудыг
МХБ-д бүртгүүлэх

- Ашигт малтмалын тухай хуулийн 5.6 дахь заалтад Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас дээш хувийг Монголбн хөрөнгийн биржээр арилжина гэж заасан.

- Хөрөнгө оруулагчдад үнэт цаасны зах зээлийн эерэг хүлээлт, итгэл бий болно.
- Компаниуд шинээр IPO, бонд гаргах сонирхол нэмэгдэнэ. Одоо байгаа ХК-үүд компанийн хэлбэрээ хадгалах сонирхол бий болно.
- Компаниудын засаглал сайжирч, ил тод нээлттэй болно. /татварын бодит тайлагнал, татварын байгууллагын ачаалал/
- Компаниуд зохистой харьцаатайгаар санхүүгийн хөшүүрэг ашиглана. Өрийн дарамт багасна.
- Мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдэнэ.
- Гадны мөнгөн урсгал орж ирнэ.



Зах зээлийн зохицуулалтын механизм

Зорилго	Хэрэгжүүлэх хэрэгслүүд	Үр дүн
Үнэт цаасны зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none">• Зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулах,• Зах зээлийг хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах• Журам, заавар батлах,• Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах• Судалгаа, шинжилгээ хийх эрсдэлийг тодорхойлох• Төсөл хөтөлбөр боловсруулах, биелэлт, үр дүнг тооцох• Тусгай зөвшөөрөл олгох, түүний эзэмшигчдэд хяналт тавих	<ul style="list-style-type: none">• Үнэт цаасны арилжаа• Зах зээлийн үнэлгээ• Зах зээлийн хөрвөх чадвар• Мэргэжлийн оролцогчдын тоо, чадавхи
Үнэт цаасны үйлчилгээг зохицуулах, хяналт тавих, хуулийн хэрэгжилтийг хангуулах		
Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалалах		

Шийдэл, гарц



Хийгдэх ажлууд	Хийх шаардлагатай ажлууд	Оролцогчид
Судалгаа, шинжилгээ	<ul style="list-style-type: none">• Татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотойгоор судалгаа• Мэргэжлийн оролцогчдын санхүүгийн чадавхийг шат дараатай, судалгаа шинэжилгээн дээр үндэслэн нэмэгдүүлэх,• Дэд бүтцийг цогц болгох судалгаа• Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг зах зээлд оруулах, үүсгэн байгуулах боломж, гарцын судалгаа• Иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх судалгаа	СЗХ, МҮЦАЭХ
Эрх зүйн шинэчлэлт	<ul style="list-style-type: none">• Зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг цогцоор боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулах,• Зах зээлийг хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах• Шинэ хуультай холбоотой нарийвчилсан журмууд батлах• Стратегийн ач холбогдол бүхий орд эзэмшигчдийн хувьцааг МХБ –ээр арилжаалах хуулийн заалтын хэрэгжилтийг хангуулах	СЗХ, МҮЦАЭХ, Уул уурхайн яам
Бүртгэл, шалгуур	Бүртгэлийн 2 тогтолцоотой болох: <ul style="list-style-type: none">• Шалгуур өндөр зах зээл• Жижиг болон өсч байгаа компаниудад зориулсан шалгуур багатай зах зээл	МХБ, МХАҮТ

Стратегийн орд



	Ордын нэр	Байршил
1	Таван Толгойн нүүрсний орд	Өмнөговь, Цогтцэций
2	Нарийн Сухайтын нүүрсний орд	Өмнөговь, Гурвантэс
3	Багануурын нүүрсний орд	Улаанбаатар, Багануур
4	Шивээ Овоогийн нүүрсний орд	Говьсүмбэр, Шивээговь
5	Мардай ураны орд	Дорнод, Дашбалбар
6	Дорнод ураны орд	Дорнод, Дашбалбар
7	Гурван булагийн ураны орд	Дорнод, Дашбалбар
8	Төмөртэй төмрийн хүдрийн орд	Сэлэнгэ, Хүдэр
9	Оюу толгой зэс, молибдений орд	Өмнөговь, Ханбогд
10	Цагаан суврага зэс, молибдений орд	Дорноговь, Мандах
11	Эрдэнэт зэс, молибдений орд	Орхон, Баян-Өндөр
12	Бүрэнхаан фосфоритын орд	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ
13	Бороо алтны орд	Сэлэнгэ, Баянгол
14	Төмөртэй овоо цайр, хар тугалганы орд	Сүхбаатар, Сүхбаатар
15	Асгат мөнгөний орд	Баян-Өлгий, Ногооннуур

Мэргэжлийн оролцогчид

БДК, Андеррайтер, Зөвлөх компаниудад баримталж байгаа бодлого нь тодорхой бус байна.



Хувь нийлүүлсэн хөрөнгө

Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Үнийн дүн (сая төг)		Өөрчлөлт
	Өмнө	Одоо	
Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа	1	100	9900%
Брокерийн үйл ажиллагаа	50	200	300%
Дилерийн үйл ажиллагаа		300	
Андеррайтерийн үйл ажиллагаа	200	1,000	400%
Арилжаа эрхлэх үйл ажиллагаа	1,000	2,000	100%
Хадгаламжийн үйл ажиллагаа	100	2,000	1900%

2013 онд МХБ-ийн нийт 79 гишүүн компанийн 24 компани ашигтай, 4 компани алдагдалгүй, 51 буюу 65 хувь нь 0.3 сая төгрөгөөс 1,797.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Монголын Үнэт Цаас Арилжаа Эрхлэгчдийн Холбоо



Нийт 45 гишүүнтэй, тэдгээрийн нийтлэг эрх ашгийг хамгаалж, тэдгээрийн хариуцлага болон чадамжийг дээшлүүлэх,

➤ МҮЦАЭХолбоо нь 1995 оны 7 дугаар сарын 8-нд анхдугаар хурлаа хийж Холбооны Дүрмийг хэлэлцэн батлаж, Удирдах Зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан түүхтэй.

➤ Холбоо нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан, үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг, ашгийн төлөө бус байгууллага

➤ Гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалж, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, мөрдүүлэх, тэдгээрийн хариуцлага болон чадамжийг дээшлүүлэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулдаг.

➤ 2012 оны 4 дүгээр сарын 2 өдөр МҮЦАЭХолбоо нь Азийн үнэт цаасны форумын албан ёсны гишүүн болсон.

➤ Тайваны үнэт цаасны холбоотой хамтран ажиллах хүрээнд туршлага солилцон хамтран ажилладаг.